



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/40 .

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн хэмжээнд гарч болзошгүй гамшигт үзэгдэл болон цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг ард иргэдийн гар утсанд “Багц мессеж” хэлбэрээр шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Б.Алтанбадралт/-д үүрэг болгосугай.

2.Тус үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр гарган аймгийн Онцгой комиссын хурлаар гишүүдэд тайлагнахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа /Б.Алтанбадралт/-д үүрэг болгосугай.

3.“Багц мессеж”-ийг ард иргэдэд хүргэх ажилд зарцуулагдах 2.520.000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ